



**МОНГОЛ УЛСЫН
ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА
ХОЛБООНЫ САЙД**

Сүхбаатарын талбай 1, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, 15160
Утас: 33 07 81, Факс: (976-11) 33 07 80,
Цахим шуудан: info@mddc.gov.mn,
Цахим хуудас: www.mddc.gov.mn

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА Д.АМАРБАЯСГАЛАН ТАНАА

2024.01.24 № 01/162
танай 2023.04.06 -ны № хэсэг 795 -т

Зөвлөмжийн хариу хүргүүлэх
тухай

Тус яам нь “Монгол Улсын хөгжлийн жилийн 2022 оны жилийн төлөвлөгөө”-ний гүйцэтгэлийн үр дүнд хийсэн аудитын тайлангаар ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Гүйцэтгэл-нийцлийн аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу “Монгол улсын хөгжлийн жилийн 2023 оны жилийн төлөвлөгөө”-ний биелэлт, хяналт-шинжилгээ, үнэлгээний тэмдэглэл, Эдийн засаг, хөгжлийн сайдад хүргүүлсэн “Монгол улсын хөгжлийн жилийн 2024 оны жилийн төлөвлөгөө”-нд хүргүүлсэн санал, тус яамнаас ирүүлсэн төлөвлөгөөний эцсийн төсөл, Сангийн сайдад хүргүүлсэн төсвийн төсөлд хүргүүлсэн саналын холбогдох материал зэргийг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт хуудастай.

Хувийг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газарт.



Н.УЧРАЛ

1524060268



МОНГОЛ УЛСЫН
ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА
ХОЛБООНЫ САЙД

Сүхбаатарын талбай 1, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, 15160
Утас: 33 07 81, Факс: (976-11) 33 07 80,
Цахим шуудан: info@mddc.gov.mn,
Цахим хуудас: www.mddc.gov.mn

2023.12.28 № 01/2719
танай _____-ны № _____-т

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД
БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ,
ХӨГЖЛИЙН САЙД
Ч.ХҮРЭЛБААТАР ТАНАА


Хэрэгжилт хүргүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийх нийтлэг журам"-д заасны дагуу тус яаманд хамаарах "Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө"-ний 4 дүгээр улирлын хэрэгжилтийн тайланг үүгээр хүргүүлж байна. Тайланд холбогдох нотлох баримтуудыг Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн систем www.unelgee.gov.mn -д оруулан баталгаажуулсан болно.


Хавсралт 8. хуудастай.



НУУЧРАЛ



1500007094



Цахим хөгжил, харилцаа холбооны яамны
2022 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн
01/12/2022 тоот албан бичгийн 1 хавсралт.

Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө
Цахим хөгжил, харилцаа холбооны яам
2023 оны жилийн эцэс

Д/д	Зорилго	Төсөл, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин, үр дүн	Зарцуулс ан хөрөнгий н хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Хүрсэн түвшин, үр дүн	Хэрэгжил тийн хувь
3. Иргэн төвтэй хөгжлийг дэмжсэн засаглалын бодлого							
1	3.1. Төрийн бүтээмжийн сэргэлтийн хүрээнд цахим хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлт, удирдлагаар хангаж, төрийн үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдү үлж, нийгмийн зөвшилцөлд үндэслэсэн	3.1.5.2. Мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх (Шинээр үүрэн холбооны дамжуулах сүлжээнд холбох суурин газрын тоо	Шинээр үүрэн холбоон ы дамжуул ах сүлжээнд холбох суурин газрын тоо	5	7,833.25	Монгол Улсын хэмжээнд 21 аймаг, 330 сумын төвд үүрэн холбооны сүлжээ бүрэн орсон бөгөөд үүрэн холбооны сүлжээнд холбогдоогүй багуудад мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхээр улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд нийт 4 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлж байна. Үүнд: 1. Хөвсгөл аймгийн 4 сумын 7 багт 2 төсөл, арга хэмжээ 2. Баянхонгор аймгийн 4 сумын 6 багт 1 төсөл, арга хэмжээ 3. Дархан-Уул аймгийн Дархан-Уул суманд 1 төсөл, арга хэмжээ нийт 14 багт харилцаа холбооны дэд бүтцийн ажил хийгдэж байна. Дээрх дэд бүтцийн ажлын хүрээнд:	90

түншлэлийн
тогтолцоог
хөгжүүлнэ.

"Хөдөөгийн алслагдсан багуудыг холбоожуулах, 4G сүлжээний үйлчилгээ /Хөвсгөл, Арбулаг, Тариалан, Ренчинлхүмбэ, Улаан-Уул, Эрдэнэбулган, Бүрэнтогтох, Цэцэрлэг, Чандмань-Өндөр, Төмөрбулаг, Цагаан-Үүр сум/" төсөл, арга хэмжээ 2021-2023 онд хэрэгжиж 2023 онд Хөвсгөл аймгийн Тариалан сумын Давааны ар багт дэд бүтцийн ажил бүрэн хийгдэж барилга байгууламжийг ББКД-67-58/23 дугаартай дүгнэлтээр байнгын ашиглалтад хүлээн авч эцсийн санхүүжилтийг олгосон.

"Хөдөөгийн алслагдсан багуудыг үүрэн холбооны сүлжээнд холбох /Хөвсгөл/" төсөл, арга хэмжээ 2022-2023 онд хэрэгжсэн бөгөөд 2023 онд Хөвсгөл аймгийн Тариалан сумын Сэлэнгэ баг, Баянзүрх сумын Тоом баг, Тариалан сумын Тавантолгой баг, Шинэ-Идэр сумын Баяннуур баг нийт 4 багт дэд бүтцийн ажил хийгдэж барилга, байгууламжийг ББКД-67-59/23 дугаартай дүгнэлтээр байнгын ашиглалтад хүлээж авч, эцсийн санхүүжилтийг олгосон.

"Үүрэн холбооны сүлжээ /Баянхонгор/" төсөл, арга хэмжээний хүрээнд Баянхонгор аймгийн 6 багт дэд бүтцийн ажил хийхээр 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдөр 1,489,659,252 төгрөгийн гэрээ байгуулж, 6 багт дэд бүтцийн ажлыг бүрэн хийж дуусгасан бөгөөд барилга байгууламжийг ашиглалтад хүлээлгэн өгөх хүсэлтийг 2023 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 23/199 дугаартай албан бичгээр ирүүлсэн. Улсын

						комисс 2023 оны 12 дугаар сарын 06-13-ны өдрүүдэд ажиллаж, 4 багт дэд бүтцийн ажлыг байнгын ашиглалтад хүлээн авахаар шийдвэрлэж, үлдсэн 2 багт дэд бүтцийг 2024 оны хавар нэмэлт сайжруулах ажлын гүйцэтгэлээр хүлээн авахаар шийдвэрлэсэн. - Мэдээлэл холбооны Дархан дэд төв /Дархан-Уул, Дархан сум, 1, 2, 3 дугаар баг/ төслийн гүйцэтгэл 80 орчим хувьтай байна. Төслийн хүрээнд дотор заслын ажил, дотор цахилгааны ажил, гадна заслын ажил, дотор холбооны ажил, дулаан дамжуулах төвийн барилгын ажил тус тус хийгдэж байна.
--	--	--	--	--	--	---

-oOo-

ᠰᠤᠮᠤᠨ

ᠰᠤᠮᠤᠨ

ᠰᠤᠮᠤᠨ

ᠰᠤᠮᠤᠨ

9022010239
6806252
AMT06231

**ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМНЫ
“УЛСЫН ХӨГЖЛИЙН 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ”-НИЙ
4 ДҮГЭЭР УЛИРЛЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

2023.12.26

Улаанбаатар хот

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд хамаарах үндсэн арга хэмжээний 4 дүгээр улирлын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үйл ажиллагааны гүйцэтгэлийг тавьсан зорилт, хүрэх түвшинтэй нь харьцуулан үр дүнг үнэлэх, дүгнэх, зөвлөмж гаргах, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй

Хяналтад авсан зорилт, арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үр дүнгийн үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасны дагуу шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг хүрсэн түвшинтэй харьцуулан үнэлэв.

Арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн түвшинг үнэлэн тогтоохдоо дээрх журмын “Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй” болон үр дүн, нотлох баримтад тулгуурлах зарчмыг баримталлаа.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

“Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө”-ний 3-т “Иргэн төвтэй хөгжлийг дэмжсэн засаглалын бодлого”-ын хэсэгт Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас “Төрийн бүтээмжийн сэргэлтийн хүрээнд цахим хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлт, удирдлагаар хангаж, төрийн үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлж, нийгмийн зөвшилцөлд үндэслэсэн түншлэлийн тогтолцоог хөгжүүлэх” үндсэн 1 томоохон зорилгыг дэвшүүлсэн.

Дээрх зорилгын хүрээнд “Мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх”-ээр тусгасан байна.

Иймд дээрх төлөвлөгөөнд туссан Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд хамаарах үндсэн арга хэмжээний хэрэгжилтийг нягтлан үзэж, цуглуулсан мэдээ, мэдээлэлд үндэслэн Хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхэд ерөнхий гүйцэтгэл 90% хувьтай байна.

Дөрөв. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт

Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд туссан Төрийн бүтээмжийн сэргэлтийн хүрээнд цахим хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлт, удирдлагаар хангаж, төрийн үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлж, нийгмийн зөвшилцөлд үндэслэсэн түншлэлийн тогтолцоог хөгжүүлэх зорилтын хүрээнд Мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байх ба улсын төсвөөс хөрөнгийн эх үүсвэрээ тогтоосон байна.

Уг арга хэмжээний хүрээнд Цахим хөгжил харилцаа холбооны яам шинээр үүрэн холбооны дамжуулах сүлжээнд 5 суурин газрыг холбохоор шалгуур үзүүлэлт төлөвлөсөн ба биелэлтийг дараах байдлаар тайлагнасан байна. Үүнд:

"Монгол Улсын хэмжээнд 21 аймаг, 330 сумын төвд үүрэн холбооны сүлжээ бүрэн орсон бөгөөд үүрэн холбооны сүлжээнд холбогдоогүй багуудад мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхээр улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд нийт 4 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлж байна. Үүнд:

1. Хөвсгөл аймгийн 4 сумын 7 багт 2 төсөл, арга хэмжээ;
2. Баянхонгор аймгийн 4 сумын 6 багт 1 төсөл, арга хэмжээ;
3. Дархан-Уул аймгийн Дархан-Уул суманд 1 төсөл, арга хэмжээ байна.

Нийт 14 багт харилцаа холбооны дэд бүтцийн ажил хийгдэж байгаа бөгөөд дэд бүтцийн ажлын хүрээнд:

- "Хөдөөгийн алслагдсан багуудыг холбоожуулах, 4G сүлжээний үйлчилгээ /Хөвсгөл аймгийн Арбулаг, Тариалан, Ренчинлхүмбэ, Улаан-Уул, Эрдэнэбулган, Бүрэнтогтох, Цэцэрлэг, Чандмань-Өндөр, Төмөрбулаг, Цагаан-Үүр сум/" төсөл, арга хэмжээ 2021-2023 онд хэрэгжиж 2023 онд Хөвсгөл аймгийн Тариалан сумын Давааны ар багт дэд бүтцийн ажил бүрэн хийгдэж барилга байгууламжийг ББКД-67-58/23 дугаартай дүгнэлтээр байнгын ашиглалтад хүлээн авч эцсийн санхүүжилтийг олгосон.

- "Хөдөөгийн алслагдсан багуудыг үүрэн холбооны сүлжээнд холбох /Хөвсгөл/" төсөл, арга хэмжээ 2022-2023 онд хэрэгжсэн бөгөөд 2023 онд Хөвсгөл аймгийн Тариалан сумын Сэлэнгэ баг, Баянзүрх сумын Тоом баг, Тариалан сумын Тавантолгой баг, Шинэ-Идэр сумын Баяннуур баг нийт 4 багт дэд бүтцийн ажил хийгдэж барилга, байгууламжийг ББКД-67-59/23 дугаартай дүгнэлтээр байнгын ашиглалтад хүлээж авч, эцсийн санхүүжилтийг олгосон.

- "Үүрэн холбооны сүлжээ /Баянхонгор/" төсөл, арга хэмжээний хүрээнд Баянхонгор аймгийн 6 багт дэд бүтцийн ажил хийхээр 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдөр 1,489,659,252 төгрөгийн гэрээ байгуулж, 6 багт дэд бүтцийн ажлыг бүрэн хийж дуусгасан бөгөөд барилга байгууламжийг ашиглалтад хүлээлгэн өгөх хүсэлтийг 2023 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 23/199 дугаартай албан бичгээр ирүүлсэн. Улсын комисс 2023 оны 12 дугаар сарын 06-13-ны өдрүүдэд ажиллаж, 4 багт дэд бүтцийн ажлыг байнгын ашиглалтад хүлээн авахаар шийдвэрлэж, үлдсэн 2 багт дэд бүтцийг 2024 оны хавар нэмэлт сайжруулах ажлын гүйцэтгэлээр хүлээн авахаар шийдвэрлэсэн.

- Мэдээлэл холбооны Дархан дэд төв /Дархан-Уул, Дархан сум, 1, 2, 3 дугаар баг/ төслийн гүйцэтгэл 80 орчим хувьтай байна. Төслийн хүрээнд дотор заслын ажил, дотор цахилгааны ажил, гадна заслын ажил, дотор холбооны ажил, дулаан дамжуулах төвийн барилгын ажил тус тус хийгдэж байна" гэжээ.

Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд тус яам шинээр үүрэн холбооны дамжуулах сүлжээнд 5 суурин газрыг холбохоор төлөвлөсөн ба одоогоор сууринг газрыг холбох ажил хийгдээгүй буюу холбоход бэлэн болгох зорилгоор дэд бүтцийн ажлуудыг хийж гүйцэтгэж байгаа талаар тайлагнасан нь тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хийгдэж дуусч байна гэж үзэхээр байна.

Тодруулбал уг арга хэмжээ бүрэн хэрэгжих шатанд байх ба дэд бүтэц байгуулагдсаны дараа 2024 оны Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн хөрөнгө оруулалтаар дээрх цэгүүдэд үүрэн холбооны үйлчилгээ хүргэх ажлыг хэрэгжүүлэхээр байна.

Дээрхээс үзвэл Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд туссан тус яаманд хамаарах арга хэмжээний шалгуур үзүүлэлтийг үндэслэлгүй төлөвлөсөн буюу Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2023 оны төсөв батлагдаагүй байх үед шууд үүрэн холбооны дамжуулах сүлжээнд 5 суурин газрыг холбохоор төлөвлөсөн нь оновчгүй төлөвлөлт болсон байна.

2023 онд хийж хэрэгжүүлсэн дэд бүтцийн ажил бүрэн хийгдэж дууссан тохиолдолд 2024 онд 14 багт буюу 5-аас их хэмжээний суурин газарт үүрэн холбооны дамжуулах сүлжээ ажиллаж эхлэхээр байгаа нь тайлан, ирүүлсэн баримтаас нотлогдож байна. Мөн Монгол Улсын хэмжээнд 21 аймаг, 330 сумын төвд үүрэн


холбооны сүлжээ бүрэн орсон бөгөөд холбогдоогүй үлдсэн багуудад дэд бүтцийн ажил хийснээр иргэд мэдээ, мэдээллийг шуурхай авах боломж бүрдэхээр байна.

Тав.Зөвлөмж

1. Төлөвлөгөөний биелэлтийг гаргахдаа үр дүн, нотлох баримтад тулгуурлах зарчмыг мэргэжилтэн болон нэгжийн удирдлагууд мөрдлөг болгон ажиллах;
2. Төлөвлөгөөний биелэлт нь тухайн байгууллага, нэгж, ажилтан бүрийн хийсэн ажлын үр дүнг харуулдаг тул хугацаа, агуулгыг анхаарах;
3. Төлөвлөгөөний биелэлтийг тайлагнахдаа хүрэх түвшний тоон үзүүлэлтийг болон чанарыг харгалзах;
4. Төлөвлөгөөнд туссан боловч салбарын бусад байгууллагаас хамаарах ажилд анхаарал хандуулж, хамтран ажиллах;
5. Төлөвлөлтийн шалгуур үзүүлэлтийг тооцоо судалгаатай, баталгаатай хэмжигдэхүйц байдлаар төлөвлөж хэвших.

Жич: Яамны газар, хэлтсийн дарга нар дээрх зөвлөмжүүдийг хүлээн авч, нэгжийн албан хаагчдадаа танилцуулах, танилцуулсан хугацаанаас хойш холбогдох арга хэмжээг авч ажиллах үүрэгтэй болно.

-оОо-





ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМНЫ
УДИРДЛАГЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2023 оны 12 сарын 26 өдөр

Дугаар 4

Улаанбаатар хот

Тайлан биелэлт хүргүүлэх тухай

Цахим хөгжил, харилцаа холбооны яамны "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл", "Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө", "Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн биелэлтийн 2023 оны жилийн эцсийн хэрэгжилтийн талаар:

Хурлыг 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 14 цагаас тус яамны "Хурлын танхим"-д эхлүүлж, Төрийн нарийн бичгийн дарга Б.Батцэцэг удирдан явуулав.

Хуралд:

1. Х.Сүрэнхорол /Бодлого, төлөвлөлтийн газрын дарга/
2. Ц.Эрдэнэбаяр /Төрийн захиргааны удирдлагын гарын дарга/
3. Б.Билэгдэмбэрэл /Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга/
4. Э.Насанбат /Кибер аюулгүй байдлын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга/
5. Л.Нямдорж /Хуулийн хэлтсийн дарга/
6. Ц.Орхонтулга /Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга/
7. Б.Золбоо /Цахим засаглалын хэлтсийн дарга/
8. Д. Батбаяр /Нийтийн мэдээллийн дэд бүтцийн хэлтсийн дарга/
9. П.Дэлгэрмаа /Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга/
10. Ц.Борхүү /Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга/
11. Хэлэлцэж байгаа асуудлуудтай холбогдуулан Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын шинжээч А.Түвшинзаяа оролцов.

Хэлэлцсэн асуудал:

Тус яамны "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл", "Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө", "Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т тусгасан тус яаманд хамаарах 1 арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг танилцуулах тухай;

СОНССОН нь:

Байгууллагын "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл", "Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө", "Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т тусгасан арга хэмжээний хэрэгжилтэд 2023 оны жилийн эцсийн байдлаар хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын шинжээч А.Түвшинзаяа танилцуулав.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

Нэг. "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл", "Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө", "Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т 2023 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг журмын дагуу холбогдох байгууллагуудад хуулийн хугацаанд хүргүүлэхийг


9022010239 6806252 AMT06231

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Ц.Борхүү/-т даалгаж шийдвэрлэв.


Хоёр. "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл"-ийн биелэлтийн тайланг тогтоосон хугацаанд тухай бүр тайлагнаж хэвшихийг Төрийн захиргааны удирдлагын газар /Ц.Эрдэнэбаяр/-т үүрэг болгов.

Хурал 14 цаг 25 минутад дуусав.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА



Б.БАТЦЭЦЭГ



9022010239 6806252 AMT06231



МОНГОЛ УЛСЫН
ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА
ХОЛБООНЫ ЯАМ


Сүхбаатарын талбай 1, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, 15160
Утас: 33 07 81, Факс: (976-11) 33 07 80,
Цахим шуудан: info@mddc.gov.mn
Цахим хуудас: www.mddc.gov.mn

2023.02.08 № 02/312
танай 2022.12.20-ны № 01/1607-Т

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД
БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН
САЙД Ч.ХҮРЭЛБААТАР ТАНАА

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний
удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1
дэх хэсэгт заасны дагуу Монгол Улсын хөгжлийн
2024 оны төлөвлөгөөний төсөлд тус яамны болон
харьяа байгууллагуудаас ирүүлсэн саналыг нэгтгэн,
хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт..... хуудастай.

ДЭД САЙД  Ж.ЭРХЭМБААТАР



1523091156

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠴᠠᠬᠢᠮ ᠬᠥᠭᠵᠢᠯ, ᠬᠠᠷᠢᠯᠴᠠᠠ
ᠬᠣᠯᠪᠤᠭᠣᠨ ᠶᠠᠮ

9022010239 6806252 AMT06231

Цахим хөгжил, харилцаа холбооны Дэд
сайдын 2023 оны 08 дугаар сарын 07-ны
өдрийн 02/08 дугаар албан бичгийн хавсралт

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСӨЛД ТУСГАХ САНАЛ

№	Код	Бодлогын үндэслэл	Үндэсний үр дүн	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Зорилгот түвшин	Санхүүжилтийн эх үүсвэр	Шаардлагатай хөрөнгийн хэмжээ/сая/	Хамтран хариуцагч
1	Y4C1T1	ЗГҮАХ Зорилт 4.1.3	Үндэсний түлхүүрийн шинэчилнэ.	ТЭЗҮ -г боловсруулж шаардлагатай тоног техөөрөмжийн техникийн шалгуур үзүүлэлт бэлэн болсон эсэх	Тийм/ үгүй	Цахим гарын үсгийн тухай хуулийн дагуу 2014 онд Үндэсний нийтийн түлхүүрийн дэд бүтцийг бий болгосон.	Үндэсний нийтийн түлхүүрийн дэд бүтцийг шинэчилж, хүчин чадлыг сайжруулсан байна.	Гадаадын зээл тусламж /Дэлхийн банкны зээл/	8,160.0	Үндэсний дата төв
2	Y4C2T2		Үндэсний тоон гарын үсгийн хэрэглээнд хөндлөнгийн аудитын байгууллагаар дүгнэлт хийлгэж олон улсын жагсаалтад оруулна.	Үндэсний тоон гарын үсэг олон улсын итгэмжлэгдсэн жагсаалтад багтсан эсэх	Тийм/ үгүй	Нийтийн түлхүүрийн дэд шинэчлэх шаардлагатай.	Олон улсын жагсаалтад орсон байна.	Гадаадын зээл тусламж /Дэлхийн банкны зээл/	300.0	Үндэсний дата төв
3	Y4C2T3		Тоон радио өргөн нэвтрүүлгийн дамжуулах сүлжээ байгуулна.	Улаанбаатар хотын Хонхорын станцыг тоон технологид шилжүүлсэн байна.	Тоо	Улаанбаатар хотын Хонхорын станцыг тоон технологид шилжүүлсэн байна.	Их хүчний аналоги радио өргөн нэвтрүүлгийн 6 станц ажилладаг	Улсын төсөв	12,100.0	Радио Телевизийн үндэсний сүлжээ УТҮГ
4	Y4C1T4	ЗГҮАХ Зорилт 4.1.5	Үндэсний хиймэл дагуул хөөргөх хууль эрхзүйн орчныг бүрдүүлнэ.	Сансрын хууль тогтоомжийн судалгааг хийсэн байна.	Төслийн тоо		Сансар судлалын хуулийн төслийг боловсруулсан байна.	Улсын төсөв	60.0	Шинжлэх ухааны академи
5	Y4C1T5		Сум, суурин газрын шилэн кабелийн сүлжээнд холбох	25 багт шилэн кабелийн сүлжээ орсон байна.	Тоо	330 сум, суурин газар шилэн кабелийн сүлжээнд холбогдсон байдаг.	25 багийг шилэн кабелийн сүлжээнд холбосон байна.	Улсын төсөв	9,000.0	-

6	Y4C1T6	Үндэсний харилцаа технологийн дэд бүтцэд халдах, эдийн засаг, нийгмийн сулруулах зорилготой халдлагыг илрүүлэх, таслан зогсоох, хариу үйлдэл үзүүлэх чадавхыг бэхжүүлэх зорилгоор Цахим мэдээллийн аюулгүй байдлын хяналт удирдлагын төв (CERT) байгуулна.	Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх төв байгуулагдсан байна.	Тоо	0	1	Гадаадын зээл тусламж /Дэлхийн банкны зээл/	7,250.0	Татнуулын ерөнхий газар
7	Y4C3T7	Үндэсний хэмжээний мэдээллийн аюулгүй байдлыг хангах сургалтын тогтолцоог бий болгоно.	Мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр сургалтад хамрагдсан төрийн албан хаагчийн тоо	Тоо	190	9000	Улсын төсөв	500.0	Боловсрол, шинжлэх ухааны яам
8	Y4C3T8	Бүх нийтийн харилцаа холбоо, мэдээллийн технологийн суурь мэдлэг чадварыг зорилгоор иргэдэд ур чадвар олгох суурь сургалтуудыг зохион байгуулах	Бүх нийтийн сургалт зохион байгуулсан эсэх	Тоо	Зохихон байгуулсан сургалт-126, иргэдийн тоо-21486	Нийт иргэдийн 30%-д сургалт хийх	Улсын төсөв	60.0	"И-Монгол академи" УТУГ
9	Y4C4T9	Бүх нийтийн цахим ур чадвар, чадамжийг дээшлүүлэх сургалт явуулах мэргэжилтэн/сургагч багш/нарыг бэлтгэх	Сургагч багш бэлдсэн эсэх	Тоо	Сургагч багш нарыг бэлтгэх төлөвлөгөө боловсруулсан	21 аймаг 9 дүүрэг тус бүрд 1 мэргэжилтэн нийт 30 мэргэжилтнийг сургалтад хамруулж мэргэшүүлсэн байна.	Улсын төсөв	600.0	"И-Монгол академи" УТУГ, БШУЯ
10	Y2C4T10	Төрийн цахим үйлчилгээний хэрэглээг нэмэгдүүлэх, иргэдэд танин мэдүүлэх арга хэмжээг зохион байгуулах	Арга хэмжээ зохион байгуулсан эсэх	Тоо	Төрийн үйлчилгээний нэгдсэн систем хэрэглэгчийн тоо 1,488,566 байна.	Төрийн цахим үйлчилгээний хэрэглээг нэмэгдүүлэх, иргэдэд танин мэдүүлж 2,000,000 хэрэглэгчтэй болсон байна.	Улсын төсөв	200.0	"И-Монгол академи" УТУГ

11	Y4C4T11	ЗГҮАХ Зорилт 4.3.1.3	Төрийн клауд дэд бүтцийн аюулгүй байдал, сүлжээ, сервер тоног төхөөрөмжүүдийн хүчин чадлыг сайжруулж, өргөтгөх	а/ Төрийн клауд дэд бүтцийн хүчин чадал, нөөцийг нэмэгдүүлж, мэдээллийн аюулгүй байдлыг сайжруулах б/ Төрийн клауд бүтцийн сүлжээний холболтын хүчин чадлыг нэмэгдүүлэх, Сүлжээний урсгалд халдлага илрүүлэх, эсэргүүцэх системийг суурилуулах, сүлжээний аюулгүй байдлыг сайжруулах в/ Монголын интернэтийн дотоод харилцан холболт /MIX/-ын дэд бүтцийн нөөц дэд бүтцийг бий болгох, MIX буюу интернэтийн дотоод харилцан холболт дээр мэдээллийн аюулгүй байдлын кибер халдлага илрүүлэх, эсэргүүцэх систем суурилуулах, дотоод интернэтийн урсгалыг сайжруулах,	Хувь	а/ Төрийн клауд дэд бүтцийн болон хадгалах нөөцийн ашиглалт, хэрэглээ 80% хүрсэн, төрийн клауд дэд бүтцийн систем нөөцөөс шалтгаалсан эрсдэл өндөр байна. б/ Төрийн клауд серверийн тоног төхөөрөмжийн дэд бүтцийн 60% нь 1Gbps холболттой байна. Гадаад сүлжээний урсгалд үндсэн халдлага илрүүлэх, эсэргүүцэх чиг үүрэг бүхий системгүй байна. в/ "MIX" -ийн дэд бүтэц нь дан ганц төхөөрөмжтэй ажиллаж байгаа өндөр эрсдэл дагуулж байна. MIXX свитчээр дамжиж буй сүлжээний урсгалд халдлагын шинж чанартай хүсэлтийг илрүүлэх, таслан зогсоох, тайлан бэлтгэх боломжгүй байна.	а/ Төрийн клауд дэд бүтцийн хүчин чадлыг 70% аар нэмэгдүүлсэн байна. б/ Төрийн зохиомол серверийн дэд бүтцийг 10Gbps хүртэл нэмэгдүүлсэн байна. Үндсэн сүлжээ болон Distribution сүлжээний төхөөрөмжийн холболтын хурдыг 10-100Gbps хүртэл нэмэгдүүлсэн байна. Гадаад сүлжээний урсгалд үндсэн халдлага илрүүлэх, эсэргүүцэх системийг бий болгосон байна. в/ Монголын интернэтийн харилцан холболтын төхөөрөмжийн нөөц бий болж, найдвартай ажиллагаа хангагдсан байна. Халдлагыг илрүүлэх, эсэргүүцэх боломжтой болно.	Улсын төсөв	17,545.0	"Үндэсний дата төв" УТҮГ
----	---------	----------------------------	--	---	------	---	--	-------------	----------	--------------------------

9022010239 6806252 AMT06231

ᠰᠤᠷᠭᠡᠨ ᠠᠵᠤᠯᠤᠰ


ᠰᠤᠷᠭᠡᠨ ᠠᠵᠤᠯᠤᠰ

ᠰᠤᠷᠭᠡᠨ ᠠᠵᠤᠯᠤᠰ

ᠰᠤᠷᠭᠡᠨ ᠠᠵᠤᠯᠤᠰ

12	У7С6Т12	"Алсын хараа-2050" Зорилт 7.5.8	Сансрын холбооны үйлдвэрлүүлэх хиймэл дагуул	Сансрын үндэсний дагуулыг үйлдвэрлүүлэх ажлыг эхэлсэн байна.	Сансрын холбооны хиймэл дагуулыг үйлдвэрлүүлэх гэрээ, хэлэлцээрийг хийж, хиймэл дагуул үйлдвэрлүүлэх ажлыг эхэлсэн байна.	Улсын төсөв	53,400.0	XX3X
13	У7С1Т13	"Алсын хараа-2050" Зорилт 7.5.11	Газрын станц байгуулах	Газрын станц байгуулах ажлыг эхэлсэн байна.	Гэрээ, хэлэлцээрийг хийж, газрын станцыг байгуулах ажлыг эхэлсэн байна.	Улсын төсөв	15,300.0	XX3X
14	У7С1Т14	"Алсын хараа-2050" Зорилт 7.5.11	Сансрын холбооны үндэсний хиймэл дагуулын програм систем нэвтрүүлэх	Сансрын үндэсний дагуулын хангамжийг авсан байна.	Сансрын холбооны үндэсний хиймэл дагуулын програм хангамжийг худалдан авч ажиллагаанд нэвтрүүлсэн байна.	Улсын төсөв	100.0	XX3X

-----000-----





МОНГОЛ УЛСЫН
ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА
ХОЛБООНЫ САЙД

Сүхбаатарын талбай 1, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, 15160
Утас: 33 07 81, Факс: (976-11) 33 07 80,
Цахим шуудан: info@mddc.gov.mn,
Цахим хуудас: www.mddc.gov.mn

2023.08.15. № 01/1634
танай _____-ны № _____-т


МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА, УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Г.ЗАНДАНШАТАР ТАНАА,
САНГИЙН САЙД Б.ЖАВХЛАН
ТАНАА

Төсвийн төсөл хүргүүлэх тухай


Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйл "Төсвийн цагалбар", 27 дугаар зүйл "Төсвийн төсөлд тавигдах шаардлага", 31 дүгээр зүйл "Төсвийн ерөнхийлөн захирагчийн жилийн төсвийн төсөл" болон бусад холбогдох хууль эрх зүйн үндэслэлийн дагуу Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны төсвийн төсөл, 2025-2026 оны төсвийн төсөөллийг боловсруулан хүргүүлж байна.

Хүлээн авч зохих журмын дагуу шийдвэрлэж өгөхийг хүсье.

Хавсралтаар танилцуулга, тооцоолол 117 хуудастай.



Н.УЧРАЛ






ҮНДЭСНИЙ ДАТА ТӨВ
УЛСЫН ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР

2024 ОНЫ УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСЛИЙН САНАЛ

Улаанбаатар хот
2023 он



**ТӨРИЙН КЛАУД ДЭД БҮТЦИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, СҮЛЖЭЭ, СЕРВЕР ТОНОГ
ТӨХӨӨРӨМЖИЙН ХҮЧИН ЧАДЛЫГ САЙЖРУУЛЖ, ӨРГӨТГӨХ**


1. УХОХ-ийн ангилал	Тоног төхөөрөмж
2. УХОХ-ийн төрөл	Улсын төсөв
ТӨСЛИЙН ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ	
3. ТӨСЛИЙН НЭР, ХҮЧ ЧАДАЛ	Төрийн клауд дэд бүтцийн аюулгүй байдал, сүлжээ, сервер тоног төхөөрөмжийн хүчин чадлыг сайжруулж, өргөтгөх
4. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ САЛБАР, ДЭД САЛБАР	Харилцаа холбооны салбар
5. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ХУГАЦАА:	
Эхлэх	2024
Дуусах	2024
6. ТӨСЛИЙН ТӨСӨВТ ӨРТӨГ	12,700,000,000 төгрөг
7. ЗАХИАЛАГЧ ЯАМ, БАЙГУУЛЛАГА	Цахим хөгжил, харилцаа холбооны яам, /"Үндэсний дата төв" УТҮГ/
ТӨСЛИЙН ТАЛААРХ НАРИЙВЧИЛСАН МЭДЭЭЛЭЛ	
8. БАЙРШИЛ (байршил, барилга байгууламжийн бүрэлдэхүүнийг заана)	Улаанбаатар Сонгинохайрхан дүүрэг 34-р хороо, Орбит
9. ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ	
Эрх зүйн үндэслэл:	
"АЛСЫН ХАРАА-2050" МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД 2021-2030 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА: 7.5.8.Мэдээллийн технологийн судалгаа шинжилгээг өргөжүүлж, мэдлэгт суурилсан инновацын шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ, уян болон хатуу дэд бүтцийг хөгжүүлнэ.	
"Цахим үндэстэн" баримтлах чиглэлийн 1.5. Дата төвийн найдвартай ажиллагаа, багтаамжийг нэмэгдүүлнэ.", -1.5.2, 1.5.3, "2.1. Төрийн үйлчилгээний процессыг оновчилно.", 2.1.2 Төрийн байгууллагын үйл ажиллагаа болон үйлчилгээнд үүлэн тооцооллыг нэвтрүүлнэ."	
Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 49 дүгээр хуралдааны тэмдэглэлд: "Үндэсний Дата Төв" УТҮГ-ын үйл ажиллагаанд үүлэн (Cloud) систем нэвтрүүлэх арга хэмжээ авах, Төрийн байгууллагуудын мэдээллийн системийг "Үндэсний Дата Төв" УТҮГ-ын үүлэн системд байршуулах арга хэмжээ авах." гэж тус тус тусгагдсан.	
Практик үндэслэл:	

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан **35** төрлийн цахим системийг хөгжүүлж, нэвтрүүлэхээр төлөвлөсний дагуу дундаж системээр тооцоход одоо байгаа дэд бүтцийн 70%-тай тэнцэхүйц нөөц бүрдүүлэх шаардлагатай.

Төрийн байгууллагуудын давхардсан хөрөнгө оруулалтын бууруулж дэд бүтцийн ашиглалт, аюулгүй байдлыг хангана. Төрөөс иргэдэд төрийн үйлчилгээг үр ашигтай, найдвартай аюулгүй, зардал багатай хүргэх.

Шинэ, шинэлэг дижитал үйлчилгээг хүргэхийн тулд төрөөс хиймэл оюун ухаан, машин сургалт, блокчэйн зэрэг шинээр гарч ирж буй технологид дасан зохицох.

Клауд дэд бүтцийн аюулгүй байдлыг хангахад, зөвхөн аюулгүй байдлын төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх нь хангалтгүй байна. Иймд Firewall болон халдлага илрүүлэх, эсэргүүцэх функцийг чиг үүргээр нь тусад салгаж ачааллыг багасгах, сүлжээний аюулгүй байдлыг хангах архитектурыг шинэчилж сайжруулах шаардлагатай.



10. ТӨСЛИЙН ЗОРИЛГО

а) МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан 6 бүлгийн 23 тэргүүлэх зорилтын дагуу 35 төрлийн цахим системийг хөгжүүлж, нэвтрүүлэхээр төлөвлөсөн байна.

б) Төрийн байгууллага, иргэдийн өсөн нэмэгдэж буй эрэлт хэрэгцээнд нийцүүлэн төрийн клауд дэд бүтцийн хүчин чадлыг нэмэгдүүлэх. Үүнд техник хангамжийг шинэчлэх, сүлжээний дэд бүтцийг сайжруулах, нөөцийн хуваарилалтыг оновчтой болгох.

в) Төрийн үйлчилгээ, иргэдэд үйлчлэх системүүд түргэн шуурхай, үр дүнтэй хүргэхийн тулд төрийн клауд дэд бүтцийн гүйцэтгэл, хурдыг оновчтой болгох

11. ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ Төрийн клауд дэд бүтцийн хүчин чадал, нөөцийг нэмэгдүүлж, мэдээллийн аюулгүй байдлыг сайжруулах,

12. ҮР ДҮН

Төсөл амжилттай хэрэгжсэнээр дараах үр дүнд хүрнэ. Үүнд:

- Иргэд төрөөс үйлчилгээ авах найдвартай дэд бүтцээр хангагдана.
- Иргэд Олон улсын туршлагад тулгуурласан аюулгүй найдвартай үйлчилгээ хүлээн авах боломж бүрдэнэ.

Үндэсний дата төвийн нийт хүчин чадал 70%-иар нэмэгдэж илүү хэмнэлттэй, өргөтгөх боломжтой, уян хатан, найдвартай, аюулгүй ажиллах дэд бүтэцтэй болсноор төрийн байгууллагууд дэд бүтцийн асуудлыг ҮДТ-д даатгах боломжтой бөгөөд ингэснээр цаг хугацаа, зардлыг хэмнэх боломжтой болно.

ҮДТ нь чиглэсэн халдлагыг илрүүлэх, эсэргүүцэх болон Firewall -г чиг үүргээр нь салгаснаар ачаалал даах чадвар 4 дахин нэмэгдэнэ

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСВИЙН ТООЦОО

№	Хөрөнгө оруулалтын нэр, төрөл	Нэгж үнэ ₮	Тоо хэмжээ	Тоног төхөөрөмжийн судалгаа	Нийт үнэ ₮
1	Сервер тоног төхөөрөмж	240,000,000	40	 PowerEdge R760 Rack Server	9,600,000,000
2	Сүлжээний switch	35,000,000	8	 S4048 10Gb	280,000,000
3	Халдлага илрүүлэх, эсэргүүцэх систем	1,410,000,000	2	 Cisco FirePower 9300 series	2,820,000,000
Бүгд					12,700,000,000



**МОНГОЛ УЛСЫН ШАДАР
САЙД БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ,
ХӨГЖЛИЙН САЙД**

Засгийн газрын II байр, Нэгдсэн үндэстний гудамж 5/1,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26 33 33,
Цахим шуудан: info@med.gov.mn

2022.04.12 № 01/57
танай _____-ны № _____-т

Санал авах тухай

Тус яамнаас Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэг болон Эдийн засаг, хөгжлийн сайдын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/167 дугаар тушаалаар баталсан "Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал"-ын дагуу яамд, байгууллагуудаас ирүүлсэн материалд үндэслэн "Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө"-ний төслийг боловсруулан, Засгийн газрын 2023 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаанд танилцуулсан.

Тус асуудлын хүрээнд Засгийн газрын 2023 оны 13 дугаар тэмдэглэл гарсан.

Засгийн газрын 2023 оны 13 дугаар тэмдэглэлийн дагуу "Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө"-ний төслийг хүргүүлж байна. Төлөвлөгөөний төсөлтэй танилцаж, саналаа 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Хавсралт:.....хуудастай.

Ч.ХҮРЭЛБААТАР

ТӨСӨЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ

2023 оны дугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар

Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын хөгжлийн 2024 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэлийг нэгдүгээр хавсралтаар, Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар, Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний хяналт-шинжилгээ, үнэлгээний үзүүлэлтүүдийг гуравдугаар хавсралтаар баталсугай.

2.Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд туссан улсын төсвөөс санхүүжүүлэх шаардлагатай төсөл, арга хэмжээг Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд тусгахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай.

3.Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс жигд ханган зохион байгуулж, түүний биелэлтийг бүтэн жилээр гаргаж, Улсын Их Хуралд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай.

4.Энэхүү тогтоолыг хэрэгжүүлж ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/ болон холбогдох бусад байгууллагад үүрэг болгосугай.

5.Энэ тогтоолыг 2023 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ГАРЫН ҮСЭГ

ТӨСӨЛ

МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛЭЭС

ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМАНД

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 4 дүгээр сарын-ны өдрийн хуралдааны дугаар тэмдэглэлд:

“... ХЭЛЭЛЦСЭН нь:

“Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: “Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

Монгол Улсын Их Хурлын 2023 оны ... дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралт

МОНГОЛ УЛСЫН 2024 ОНД БАРИМТЛАХ БОДЛОГЫН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ

Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөг “Алсын хараа 2050”, “Шинэ сэргэлтийн бодлого”, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т үндэслэн боловсрууллаа.

Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгасан улсын төсвөөс санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлд бүрэн тусгаж, хэрэгжүүлнэ.

Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хадгалах хүрээнд Засгийн газар нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг дотоодын нийт бүтээгдэхүүний 2 хувиас илүүгүй алдагдалтай байхаар төлөвлөж хэрэгжүүлэх, төсвийн үр ашгийг эрс дээшлүүлж бодлогын орон зайг нэмэгдүүлэх; Монголбанк төсвийн шинжтэй үйл ажиллагааг хэрэгжүүлэхээс бүрэн татгалзах, инфляцыг зорилтот түвшинд тогтвортой хадгалахад мөнгөний бодлогын тохируулгыг оновчтой хийх, цаашид инфляцын зорилтот түвшнийг үе шаттай бууруулах суурь нөхцөлийг бүрдүүлэх зарчмыг баримтална.

Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь 2024 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэлд тусаагүй төсвийн ерөнхийлөн захирагч болон хөтөлбөрийн үр дүнг сайжруулах үндсэн үйл ажиллагаа болон үргэлжилж буй төсөл, арга хэмжээг төсвийн алдагдлын хязгаарт багтаан төлөвлөж, хэрэгжүүлнэ.

Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний төслийг боловсруулахдаа Монгол Улсын 2022 оны УИХ-ын 23 дугаар тогтоолын 2.3-т заасныг үндэслэн дараах тэргүүлэх 8 чиглэлийг тодорхойллоо.

Нэг. Экспортыг нэмэгдүүлнэ.

- 1.1. Нүүрсний экспортын биет хэмжээг 50 сая тонн, зэсийн экспортын биет хэмжээг 1.5 сая тонн, газрын тосны экспортын биет хэмжээг 6.0 сая баррельд хүргэж уул уурхайн салбарын экспортыг нэмэгдүүлнэ.
 - 1.1.1. Экспортын биет хэмжээг нэмэгдүүлэх авто зам, төмөр зам, төмөр замын холболтын төслүүдийг хэрэгжүүлж тээврийн салбарын ачаа тээвэрлэх хүчин чадлыг нэмэгдүүлнэ.
 - 1.1.2. Хилийн боомтуудын ачаа болон зорчигч нэвтрүүлэх, логистикийн үйлчилгээний хүчин чадлыг нэмэгдүүлэх төслүүдийг хэрэгжүүлнэ.
- 1.2. Гадаад худалдааг хөнгөвчлөх, экспортыг төрөлжүүлэх, ХАА-н гаралтай бүтээгдэхүүний боловсруулалтын түвшнийг ахиулах замаар уул уурхайн бус экспортыг нэмэгдүүлнэ.

- 1.2.1. Уул уурхайн бус бүтээгдэхүүнд зориулсан экспортын санхүүжилт, даатгал, төлбөрийн баталгаа, зээлийн батлан даалт зэргээр экспортыг дэмжих санхүүжилтийн тогтолцоог бий болгоно.
- 1.2.2. Экспортын баримжаатай хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулалтын түвшнийг ахиулах үйлдвэр технологийн паркуудын дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг хийнэ.
- 1.2.3. Олон улсын худалдаанд хориг саад үүсгэдэг мал, амьтны гоц халдварт өвчний тархалтыг бүрэн хяналтад авч, өвчнөөр тайван байдлыг хадгална.
- 1.2.4. Гадаад худалдааны процесс, хилийн хяналтын байгууллагуудын үйл ажиллагааг хялбаршуулан, шаарддаг гэрчилгээ, зөвшөөрөл, бичиг баримтын тоог боломжит хамгийн бага түвшинд хүртэл бууруулж "Гадаад худалдааны цахим нэг цонхны үйлчилгээ"-г нэвтрүүлж, гадаад худалдаанд зарцуулж буй цаг хугацааг 72 цагт хүргэнэ.
- 1.2.5. Ноолуур, мах, арьс шир, самар, эмийн ургамал, хүнсний бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх, экспортын орцыг тарифаас чөлөөлөх, боловсруулалтын түвшнийг ахиулах хөрөнгө оруулалтыг дэмжиж экспортыг төрөлжүүлнэ.

Хоёр. Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.

- 2.1. Хөрөнгө оруулагчдад дэмжлэг, үйлчилгээ үзүүлэх, хөрөнгө оруулалт татах, хамгаалах цогц механизмыг бүрдүүлэх замаар хөрөнгө оруулалт хийх, бизнесийн үйл ажиллагаа эрхлэх таатай орчныг бүрдүүлнэ.
 - 2.1.1. Хөрөнгө оруулалт хийх, бизнесийн үйл ажиллагаа эрхлэхэд төрөөс зөвшөөрөл авахад дэмжлэг тусалцаа үзүүлэх, мэдээ мэдээллээр хангах, зөвлөгөө өгөх цогц үйлчилгээг үзүүлж, хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах, гаргасан гомдлыг цахимаар хүлээн авах, шийдвэрлэх, төрөөс бизнесийн үйл ажиллагаанд хийгддэг давхардсан хяналт шалгалтыг бууруулна.
 - 2.1.2. Банк, санхүүгийн салбарын өрсөлдөөнийг нэмэгдүүлэх замаар санхүүгийн үйлчилгээний зардлыг бууруулж, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийн хэмж.
 - 2.1.3. Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр, Чөлөөт худалдааны хэлэлцээр, Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай хэлэлцээрүүдийг байгуулж аж ахуйн нэгж байгууллагуудад гадаад худалдаа, экспорт хийх таатай нөхцөл, боломжийг бүрдүүлнэ.
- 2.2. Геологи, хайгуулын ажлыг эрчимжүүлж, ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олголтыг нэмэгдүүлэх, улмаар ашигт малтмалын батлагдсан нөөцийг өсгөх, зэсийн ордын ашиглалтыг нэмэгдүүлэх замаар уул уурхайн салбар дахь хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.
- 2.3. Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр, нүүрс баяжуулах үйлдвэр, гангийн үйлдвэр, ураны олборлолт, хүдрийн баяжмал боловсруулах

- үйлдвэр байгуулахад хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт татах замаар боловсруулах үйлдвэрийг нэмэгдүүлнэ.
- 2.4. Эрчим хүчний найдвартай эх үүсвэрийг нэмэгдүүлэх замаар дотоодын хэрэгцээг бүрэн хангаж, эрчим хүч экспортлох суурь нөхцөлийг бүрдүүлнэ.
- 2.5. Соёлын бүтээлч үйлдвэрлэлд хөрөнгө оруулалт татаж, соёлын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх замаар соёлын салбарыг эдийн засгийн эргэлтэд оруулна.
- 2.6. Чөлөөт бүсүүдийн инженерийн дэд бүтцийг хөгжүүлж, хөрөнгө оруулалт татах нөхцөлийг бүрдүүлнэ.

Гурав. Хүний хөгжлийн үзүүлэлтийг сайжруулна.

- 3.1. Олон улсын стандартад нийцсэн мэргэжилтэй хүний нөөц бэлтгэх тогтолцоог бүрдүүлж, ур чадвартай боловсон хүчнийг нэмэгдүүлнэ.
- 3.1.1. Бүс нутгийн хэрэгцээ шаардлагад нийцсэн төрөлжсөн технологийн коллеж (Коосэн)-ийг бүх аймагт хөгжүүлж, өөрчлөн зохион байгуулах замаар эрэлтэд нийцсэн ур чадвартай хүний нөөцийг бэлтгэж, нэмэгдүүлнэ.
- 3.1.2. ЕБС-ийн сургалтын хөтөлбөр дэх англи хэлний хэрэглээг нэмэгдүүлнэ.
- 3.1.3. Судалгааны үр дүнд бий болсон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эрдэм шинжилгээний өгүүлэл, бүтээл, патентыг эдийн засгийн эргэлтэд оруулна.
- 3.1.4. Боловсролын салбарын хүртээмжийг нэмэгдүүлэх хөрөнгө оруулалтыг хийнэ.
- 3.2. Нийгмийн хамгааллын салбарт нийгмийн даатгалын шударга тогтолцоог бий болгох, төрийн албан хаагчдын цалинг үе шаттайгаар нэмэгдүүлэх, нийгмийн зорилтод бүлгийг зөв тодорхойлж, нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийг хэмжээг нэмэгдүүлэх замаар нийгмийн баталгааг сайжруулна.
- 3.2.1. Нийгмийн даатгалын тогтолцоог өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн нийт хувь нэмрээс хамааруулан тэтгэврийг шударга тогтоох тогтолцоонд шилжүүлнэ.
- 3.2.2. Үр дүнд суурилсан удирдлагын нэгдсэн тогтолцоог бүрэн шилжүүлэх замаар төрийн албаны бүтцийн шинэчлэлийг хийж, төрийн албан хаагчдын цалин хөлсийг ажлын бүтээмж, үр дүнтэй уялдуулан нэмэгдүүлнэ.
- 3.2.3. Цалинг цагаар тооцдог системд бүрэн шилжинэ.
- 3.2.4. Нийгмийн халамжийн системийг шинэчлэх замаар нийгмийн халамж зайлшгүй хүртэх зорилтот бүлгийг оновчтой тодорхойлж, мөнгөн халамжийг халж, тусгайлсан картаар олгоно.
- 3.2.5. Тэтгэвэр, тэтгэмжийг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлнэ.

- 3.3. Эрүүл мэндийн салбарын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, өвчлөл, нас баралтыг бууруулна.
- 3.3.1. Дотоодод худалдаалж байгаа эмийн чанарыг олон улсын стандартад нийцүүлнэ.
- 3.3.2. Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх хөрөнгө оруулалтыг хийнэ.
- 3.3.3. Нийтийн биеийн тамир, спортын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.

Дөрөв. Аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

- 4.1. Аялал жуулчлалын салбарын бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх, дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг түлхүү хийх, агаарын тээврийг либералчлах ажлыг эрчимжүүлж, нислэгийн тоог өсгөж, жуулчдын тоо, аялал жуулчлалын орлогыг нэмэгдүүлнэ.
- 4.1.1. Аялал жуулчлалын бүс нутгуудад авто замын дэд бүтцийн чанар, хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.
- 4.1.2. Аялал жуулчлалыг дэмжсэн зөөлөн дэд бүтцийн бодлогын арга хэмжээг хэрэгжүүлж, жуулчдад зориулсан бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлнэ.
- 4.1.3. Агаарын тээврийн либералчлалыг хэрэгжүүлж, Дорнод, Ховд, Хөвсгөл аймгийн нисэх буудлыг 4C, Өмнөговь аймгийн нисэх буудлыг 4D ангиллын агаарын хөлөг хүлээн авах хүчин чадлыг нэмэгдүүлж аэродром, зорчигч үйлчилгээний цогцолбор байгуулах замаар агаарын тээврээр зорчсон жуулчдын тоог нэмэгдүүлнэ.

Тав. Хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулна.

- 5.1. Хүн амын хүнсний хэрэгцээний гол нэрийн бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, импортын хамаарлыг бууруулах, нийлүүлэлтийн сүлжээ, аюулгүй байдлыг хангах тогтолцоог бүрдүүлнэ.
- 5.1.1. Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн дэмжлэгийг эцсийн үр дүнд чиглүүлж оновчтой болгох хууль эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
- 5.1.2. Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх тохиромжтой байршлуудад УТП байгуулах хувийн хэвшлийг инженерийн дэд бүтэц, санхүүжилтийн эх үүсвэрээр дэмжинэ.
- 5.1.3. НӨАТ-ын системд тулгуурлан хүнсний бүтээгдэхүүний хангамж, аюулгүй байдлыг хянах, бүртгэх, дэмжлэгийг оновчтой болгох цахим системийг хөгжүүлнэ.
- 5.1.4. Хүнсний бүтээгдэхүүний чанар, баталгаажуулалтын лабораторийг нэмэгдүүлэх замаар стандартын шаардлага хангасан хүнсний бүтээгдэхүүний хангамжийг нэмэгдүүлнэ.

ТӨСӨЛ



МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСӨЛ

ГАРЧИГ

НЭГ. МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСЛИЙН ЗОРИЛГО, ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ	6
1.1. Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний төслийн зорилго	6
1.2. Монгол Улсын хөгжлийн 2024 оны бодлогын тэргүүлэх чиглэл	6
ХОЁР. МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН 2022 ОНЫ УРЬДЧИЛСАН ГҮЙЦЭТГЭЛ	7
2.1. Макро эдийн засгийн 2022 оны урьдчилсан гүйцэтгэл.....	7
2.2. Салбарын 2022 оны урьдчилсан гүйцэтгэл	17
ГУРАВ. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН 2024 ОНЫ ЧИГ ХАНДЛАГА, ТӨСӨӨЛӨЛ	62
3.1. Макро эдийн засгийн 2024 оны төсөөлөл	64

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн бүтэц.....	7
Зураг 2. Төсвийн орлого, зарлагын өөрчлөлт	10
Зураг 3. Төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл	10
Зураг 4. Жилийн инфляц ба зорилтот түвшин	11
Зураг 5. Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлт, пассив тал	11
Зураг 6. Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлт, актив тал	11
Зураг 7. Арилжааны банкуудын зээлийн жилийн өсөлтийн бүрэлдэхүүн	12
Зураг 8. Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь	12
Зураг 9. Улирлын нөлөөг арилгасан ажиллагсдын тоо	12
Зураг 10. Ажиллах хүчний оролцооны түвшин.....	12
Зураг 11. Ажилгүйдлийн түвшин	12
Зураг 12. Ажиллах хүчний оролцооны түвшин.....	13
Зураг 13. Мэргэжлээрээ хөдөлмөр эрхлэлт, 2020 он	13
Зураг 14. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, 2022 он	14
Зураг 15. Нэг ажилтанд ногдох капитал ба бүтээгдэхүүний өсөлт	14
Зураг 16. Төлбөрийн тэнцэл.....	15
Зураг 17. ГВАН, хүрэлцээт түвшин	15
Зураг 18. Гадаад худалдааны нийт бараа эргэлт.....	15
Зураг 19. Хүнсний ногооны үйлдвэрлэл	17
Зураг 20. Гурил, тэжээлийн үйлдвэрт олгосон татаас, урамшуулал.....	21
Зураг 21. Гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалт.....	22
Зураг 22. Ачаа тээвэрлэлт	24
Зураг 23. Ашиглалтад орсон зам, гүүр	25
Зураг 24. Тусгай зөвшөөрөл олголт.....	29
Зураг 25. Монгол Улсад ирсэн гадаадын жуулчдын тоо, орлогын өөрчлөлт.....	30
Зураг 26. Мэдээлэл, харилцаа холбооны салбарын үндсэн үзүүлэлтүүд	31
Зураг 27. Хүн амын өсөлт.....	32
Зураг 28. Хүн амын нас, хүйсийн суварга	32
Зураг 29. Өрхийн тоо	33
Зураг 30. Бие бялдрын түвшин тогтоох сорилд хамрагдагчдын үнэлгээ	34
Зураг 31. 5 настай хүүхдийн цэцэрлэгт хамрагдалтын хувь	35
Зураг 32. Сургуулийн өмнөх боловсролын үндсэн багш, туслах багшийн тоо	36
Зураг 33. Нийт суралцагчдын тоо, хүйсийн харьцаа	38
Зураг 34. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага	43
Зураг 35. Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэврийн хэмжээ	43
Зураг 36. Ядуурлын түвшин	44
Зураг 37. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт	46
Зураг 38. Ажиллагчдын сарын дундаж цалин	46
Зураг 39. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ.....	47
Зураг 40. УИХ-аар батлуулсан хуулийн төслийн тоо	58
Зураг 41. Дэлхийн эдийн засгийн өсөлт	62
Зураг 42. Зэсийн үнэ	63
Зураг 43. Алтны үнэ	63
Зураг 44. Төмрийн хүдрийн үнэ.....	64
Зураг 45. Нүүрсний үнэ	64
Зураг 46. Газрын тосны үнэ.....	64

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Эдийн засгийн өсөлтийн бүтэц.....	7
Хүснэгт 2. Хөнгөн үйлдвэрийн салбарын гол нэрийн бүтээгдэхүүний худалдаа.....	19
Хүснэгт 3. Зорчигчдын тоо	25
Хүснэгт 4. Цэцэрлэг, бүлгийн тоо.....	35
Хүснэгт 5. Цэцэрлэгийн багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, 2022 он.....	37
Хүснэгт 6. Ерөнхий боловсролын сургууль, суралцагчид	37
Хүснэгт 7. Их, дээд сургууль, коллежид суралцагчид	38
Хүснэгт 8. Дээд боловсролын сургалтын байгууллагад ажиллагчид	39
Хүснэгт 9. Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдагчид	42
Хүснэгт 10. Хөдөлмөрийн салбарын үндсэн үзүүлэлтүүд.....	45
Хүснэгт 11. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт.....	46
Хүснэгт 12. Ойн нөхөн сэргээх ажил.....	51
Хүснэгт 13. Цөлжилтийн үйл явцын хандлага.....	52
Хүснэгт 14. Улсын хилээр нэвтэрсэн зорчигч, тээврийн хэрэгслийн судалгаа.....	59

Төсөл

Монгол Улсын Их Хурлын 2023 оны ... дугаар
тогтоолын 2 дугаар хавсралт


МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

ТЕЗ-ийн үр дүн	Хөтөлбөрийн үр дүн	Бодлогын үндэслэл	Төсөл, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Үр дүнгийн үзүүлэлт		Санхүүжилт		Үндсэн хариуцагч
						Суурь түвшин /2022 он/	Зорилтот түвшин /2024 он/	Санхүүжилт, сая.төг	Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал	
"АЛСЫН ХАРАА-2050" МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ БОДЛОГО: ЭДИЙН ЗАСАГ БҮЛГИЙН ХҮРЭЭНД:										
ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 1. ЭКСПОРТЫГ НЭМЭГДҮҮЛНЭ.										
1.1. Ачаа тээвэрлэх хүчин чадлыг нэмэгдүүлнэ.	1.1.1. Төмөр замын ачаа тээвэрлэх хүчин чадлыг 60 сая тоннд хүргэнэ.	АХ-8.1.8, МУХТЖУЧ-8.1.2, ЗГҮАХ-3.6.1	1.1.1.1. Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан 18.9 км холболтын төмөр зам, ачаа тээврийн шилжүүлэн ачих терминалыг барих	Барилгын ажлын гүйцэтгэл	Хувь	-	20	154,000.00	Бусад эх үүсвэр	ЗТХЯ
		АХ-8.1.3, МУХТЖУЧ-8.1.2, ЗГҮАХ-3.6.1	1.1.1.2. Ханги-Мандал боомтын хил дамнасан холболтын төмөр зам, ачаа тээврийн шилжүүлэн ачих терминалыг барих	Төмөр замын урт	Км	-	10	175,885.00	Төр-хувийн хэвшлийн түншлэл	ЗТХЯ
		АХ-8.1.3, МУХТЖУЧ-8.1.2, ЗГҮАХ-3.6.1	1.1.1.3. Улаанбаатар төмөр замын хүчин чадлыг нэмэгдүүлэх /269 км хос замын оруулга/	Хүчин чадал	Сая тонн	30	54	-	Бусад эх үүсвэр	ЗТХЯ
		АХ-8.1.3, МУХТЖУЧ-8.1.2, ЗГҮАХ-3.6.1	1.1.1.4. Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн 1,255 км төмөр зам, хилийн боомтын холболт, ачаа тээврийн шилжүүлэн ачих терминалыг барих	Барилгын ажлын гүйцэтгэл	Хувь	-	5	213,941.00	Төр-хувийн хэвшлийн түншлэл	ЗТХЯ
		АХ-8.1.3, МУХТЖУЧ-8.1.2, ЗГҮАХ-3.6.2	1.1.1.5. Чойбалсан-Хөөт-Бичигт чиглэлийн 426.7 км төмөр зам, хилийн боомтын холболт, ачаа тээврийн шилжүүлэн ачих терминалыг барих	Барилгын ажлын гүйцэтгэл	Хувь	-	10	142,627.33	Төр-хувийн хэвшлийн түншлэл	ЗТХЯ
		АХ-8.1.1, МУХТЖУЧ-8.1.2, ЗГҮАХ-3.6.1	1.1.2.1. Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн 478 км тусгай зориулалтын авто зам барих	Барилгын ажлын гүйцэтгэл	Хувь	43.2	100	474,154.80	Төр-хувийн хэвшлийн түншлэл	ЗТХЯ

№	Зорилтот үр дүн	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь он	Суурь түвшин	Зорилтот түвшин	Мэдээллийн эх сурвалж	Мэдээлэл цуглуулах арга зүй	Мэдээлэл цуглуулах давтамж	Хариуцах байгууллага
	нэмэгдүүлнэ.	этгээдийн хөрөнгийн өгөөж /ROA/								
7.2.3	Төрийн цахим үйлчилгээний хэрэглэгчийн тоог 2 саяд хүргэнэ.	Төрийн үйлчилгээг цахимаар хүртэгчид	Хувь	2022	1,488,566.0	2,000,000.0	ЦХХХЯ	Статистик мэдээ	Жилд нэг удаа	ЦХХХЯ
7.2.4	Харилцаа холбооны дэд бүтцийг сайжруулна.	Харилцаа холбооны дэд бүтцийн индекс /НҮБ-ын цахим засгийн судалгаа/	Оноо	2022	0.7	0.1	ЦХХХЯ	Статистик мэдээ	Жилд нэг удаа	ЦХХХЯ
7.2.5	Газрын харилцааны үйлчилгээг хялбаршуулна.	1,000 газар эзэмшигчид ногдох маргаан, зөрчил	Тоо	2021	5.1	4.1	БХБЯ	Статистик мэдээ	Жилд нэг удаа	БХБЯ
7.2.6	Эрэн хайх ажиллагааны чанарыг нэмэгдүүлнэ.	Арга хэмжээний хэрэгжилт	Хувь	2022	60.0	100.0	ОБЕГ	Статистик мэдээ	Жилд нэг удаа	ОБЕГ
7.3.1	Цэргийн мэргэжил олгох сургалт болон Энхийг сахиулах ажиллагаанд оролцогчдын тоог нэмэгдүүлнэ.	Цэргийн мэргэжил олгох сургалт болон Энхийг сахиулах ажиллагаанд оролцогчид	Тоо				БХЯ	Статистик мэдээ	Жилд нэг удаа	БХЯ
7.3.2	Хил орчмын аюулгүй байдлыг сайжруулна.	Хил орчмын дэглэмийн зөрчил	Хүн/удаа	2022	85/819	68/655	ХХЕГ	Статистик мэдээ	Жилд нэг удаа	ХХЕГ
8.1.1	Ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг нэмэгдүүлнэ.	Ойгоор бүрхэгдсэн талбайн эзлэх хувь	Хувь	2019	7.7	8.5	БОАЖЯ	Статистик мэдээ	Жилд нэг удаа	БОАЖЯ
8.1.2	Байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.	Эргүүлэн болон дахин ашигласан усны хэмжээ	Хувь	2021	10.0	12.5	БОАЖЯ	Статистик мэдээ	Жилд нэг удаа	БОАЖЯ
8.1.3	Гадаргын усны хуримтлалыг нэмэгдүүлнэ.	Төслийн хэрэгжилт	Хувь	2022	-	10.0	БОАЖЯ	Статистик мэдээ	Жилд нэг удаа	БОАЖЯ
		Тарималжуулсан ургамлын зүйл	Тоо	2021	10.0	12.0	БОАЖЯ	Статистик мэдээ	Жилд нэг удаа	БОАЖЯ
8.1.4	Ашиглалтад өртөмтгий амьтан, ургамлын ашиглалтын нөөцийг бүсчлэн бий болгоно.	Амьдрах орчныг тэтгэх арга хэмжээ авсан болон зориудаар өсгөн үржүүлсэн нэн ховор, ховор амьтны зүйл	Тоо	2021	3.0	5.0	БОАЖЯ	Статистик мэдээ	Жилд нэг удаа	БОАЖЯ

ТЭЗ-ийн үр дүн	Хөтөлбөрийн үр дүн	Бодлогын үндэслэл	Төсөл, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Үр дүнгийн үзүүлэлт		Санхүүжилт		Үндсэн хариуцагч
						Суурь түвшин /2022 он/	Зорилготой түвшин /2024 он/	Санхүүжилт, сая.төг	Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал	
7.2. Төрийн бүтээмжийг дээшлүүлнэ.	7.2.1. Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үр ашгийг нэмэгдүүлнэ.	АХ-4.3.16, МУХТЖҮЧ-5.6.2, ЗГҮАХ-4.2.1	7.1.1.2. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог боловсронгуй болгох	ФАТФ болон мөнгө угаахтай тэмцэх Ази номхон далайн бүсийн бүлгийн зөвлөмжийг хэрэгжүүлсэн байдал	Тоо	39	40	40.00	Улсын төсөв	СЗХ
		АХ-5.2.19, МУХТЖҮЧ-5.1.3, ЗГҮАХ-4.1.4	7.2.1.1. Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн мэдээллийн нэгдсэн системийг бий болгох	Арга хэмжээний хэрэгжилт	Хувь	40	90	-	Улсын төсөв	ТӨБЗГ
	7.2.2. Төрийн цахим үйлчилгээний хэрэглэгчийн тоог 2 саяд хүргэнэ.	АХ-5.2.19, МУХТЖҮЧ-5.1.1, ЗГҮАХ-4.4.10	7.2.1.2. Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2024 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх	Олон нийтийн шууд хяналтад оруулсан төрийн өмчит компани	Тоо	1	2	40.00	Улсын төсөв	ТӨБЗГ
		АХ-7.5.3, МУХТЖҮЧ-7.5.2, ЗГҮАХ-4.1.1	7.2.2.1. Төрийн клауд дэд бүтцийн аюулгүй байдал, сүлжээ, сервер тоног төхөөрөмжүүдийн хүчин чадлыг сайжруулж өргөтгөх	Гадаад сүлжээний урсгалд үндсэн халдлага илрүүлэх, эсэргүүцэх чиг үүрэг бүхий систем	Тоо	-	1	12,700.00	Улсын төсөв	ЦХХХЯ
7.3. Харилцаа холбооны дэд бүтцийг сайжруулна.	7.2.3. Харилцаа холбооны дэд бүтцийг сайжруулна.	АХ-7.5.3, МУХТЖҮЧ-7.5.2, ЗГҮАХ-4.1.2	7.2.2.2. Цахим мэдээллийн аюулгүй байдлын хяналт удирдлагын төв /CERT/ байгуулах	Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх төв байгуулах ажлын явц	Хувь	-	100	7,250.00	Гадаадын зээл	ЦХХХЯ
		АХ-7.5.3, МУХТЖҮЧ-5.3.3, ЗГҮАХ-4.1.6	7.2.2.3. Гадаад харилцааны салбарын мэдээллийн аюулгүй байдлыг хангах, хамгаалалтын нэгдсэн системийг нэвтрүүлэх	Нэвтрүүлсэн систем	Тоо	-	1	1,372.00	Улсын төсөв	ГХЯ
	7.2.3. Харилцаа холбооны дэд бүтцийг сайжруулна.	АХ-5.3.6, МУХТЖҮЧ-7.5.2, ЗГҮАХ-4.1.3	7.2.3.1. Интернэтийн харилцан холболт, аюулгүй байдлыг сайжруулах	Монголын интернэтийн дотоод харилцан холболт /МХ/-ын дэд бүтцийн нөөц дэд бүтцийг бий болгох ажлын явц	Хувь	-	100	4,680.00	Гадаадын зээл	ЦХХХЯ

Зураг 25. Монгол Улсад ирсэн гадаадын жуулчдын тоо, орлогын өөрчлөлт



Эх сурвалж: Байгаль орчин, аялал жуулчлалын яам

Монгол Улс 2022 онд нийт 290 гаруй мянган гадаадын жуулчдаас 278 сая ам.долларын экспортын орлого оруулж, 1,000 гаруй аж ахуйн нэгж байгууллагууд 50.0 мянга орчим ажлын байрыг бий болгож, 750 тэрбум төгрөгийн орлого олсон байна.

Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас аялал жуулчлалын салбар тэг зогсолт хийж, урьдчилсан байдлаар зөвхөн жуулчин хүлээж авдаг тур операторуудын орлого 80 хувиар, зочид буудлуудын орлого 63 хувиар, жуулчны баазуудын орлого 84 хувиар, ресторануудын орлого 50 хувиар, тэдгээрт ажиллаж буй ажиллах хүчний нөөцийн алдагдал 25-75 хувиар тус тус хумигджээ.

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 6 дугаар тогтоолоор Ковид-19 цар тахалтай тэмцэх, эрсдэлийг бууруулах зорилгоор улсын хэмжээнд тогтоосон гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэргийг цуцалснаар Монгол Улс хилээ албан ёсоор бүрэн нээсэн.

Монгол Улсын виз олгох журам шинэчлэгдсэнтэй уялдуулан Засгийн газрын тогтоолоор байгуулагдсан 46 боомтын олон улсын ажиллагаатай 14 боомтын сэргэлтийг богино хугацаанд хийж, авто замын боомтоор автомашинтай аяллыг оруулахыг дэмжих нь хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх, хил орчмын жуулчдын тоог 150,000 болгон нэмэгдүүлэхэд ач холбогдол бүхий шийдэл болох юм.


2.2.7. Харилцаа холбоо, мэдээлэл технологи

Олон улсад өрсөлдөх чадвар бүхий үндэсний шинжлэх ухаан, технологи, инновацыг хөгжүүлэх замаар харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарыг эдийн засгийн тэргүүлэх чиглэлийн нэг болгох зорилт тавьж, “Цахим Үндэстэн” болох уриалгыг дэвшүүлэн ажиллаж байна. Энэхүү ажлын хүрээнд дижитал дэд бүтэц, цахим засаглал, мэдээллийн аюулгүй байдал, тоон бичиг үсгийн чадавх, инновац үйлдвэрлэл, үндэсний хөгжлийн хурдасгуурыг хөгжүүлж байна.

Улсын хэмжээнд мэдээлэл, харилцаа холбооны салбарын нийт орлого 2022 онд 1.7 их наяд төгрөг болж, өмнөх оноос 127.8 тэрбум төгрөгөөр буюу 8.0 хувиар өссөн байна. Энэхүү өсөлтөд утасгүй үйл ажиллагааны орлого 9.6 хувиар, өргөн

нэвтрүүлэг бэлтгэх, дамжуулах үйл ажиллагааны орлого 17.9 хувиар, утсан холбооны орлого 14.6 хувиар нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

Зураг 26. Мэдээлэл, харилцаа холбооны салбарын үндсэн үзүүлэлтүүд



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Интернэт хэрэглэгчдийн тоо 2022 оны эцэст 4.2 сая болж, өмнөх оноос 50.2 мянган хэрэглэгчээр буюу 1.2 хувиар өссөн байна.

Нийт шуудан, илгээмжийн хэмжээ 8.8 сая болж, өмнөх оноос 2.8 сая ширхгээр буюу 45.7 хувиар өссөн байна. Энэхүү өсөлтөд дотоодын шуудан, илгээмж 27.0 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Цахим гарын үсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад заасны дагуу “Мон Пасс СА” ХХК, “Тридум Э-Секьюрити” ХХК, “Нью Компасс” ХХК, “Ви Эс Эм” ХХК, “Ай Си Ти Групп” ХК нар тоон гарын үсгийн гэрчилгээ олгох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчээр ажиллаж, нийт 75,921 тоон гарын үсгийн гэрчилгээг хуулийн этгээдэд олгоод байна. Мөн “Үндэсний дата төв” Улсын төсөвт үйлдвэрийн газраас төрийн албан хаагчдад тоон гарын үсгийн гэрчилгээ олгох ажлыг хариуцан гүйцэтгэж, нийт 64 мянга орчим тоон гарын үсэг олгосон бол 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс хууль хэрэгжиж эхэлснээс хойш Улсын бүртгэлийн байгууллагаас 21 аймаг, 330 сум, 9 дүүрэг, 171 хорооны бүртгэлийн нэгжээр дамжуулан 16 насанд хүрсэн нийт 179,397 иргэнд тоон гарын үсгийн гэрчилгээг иргэний үнэмлэхийн чипэд суулгаж олгосон.

Дижитал дэд бүтцийн бэлэн байдлыг хангах хүрээнд улсын хэмжээнд дамжуулах сүлжээний багтаамжийг нэмэгдүүлэх, үнэ тарифыг бууруулах бодлого боловсруулж ажилласны үр дүнд 2022 оны эхний хагас жилийн байдлаар хот хоорондын шилэн кабелийн урт 40,760 км, хот доторх шилэн кабелийн урт 7,223 км хүрч, шилэн кабельд холбогдсон сумын тоо 227 болсон.

Харилцаа холбоо болон өргөн нэвтрүүлгийн үйлчилгээнд өнөөгийн байдлаар 6 аж ахуйн нэгж, байгууллага хиймэл дагуулын нийт 444 МГц давтамжийн зурвас гаднын хиймэл дагуулаас түрээслэн ашиглаж, хэрэглэгчдэд интернэт, үүрэн холбоо, өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ хүргэхээс гадна радио навигацийн холбоонд ашиглаж байна.

2.2.8. Хүний хөгжил

Хүн амын өсөлт, бүтэц: Хүн ам зүйн үндсэн бүрэлдэхүүн болох хүн амын өсөлтийн хандлагыг сүүлийн 10 жилээр авч үзэхэд, Монгол Улсын нийт хүн ам 2.9-